




НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗРЫН
НАЛАЙХ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

НАЛАЙХ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2021-2025 ОН	3
 ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	4-5
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5-7
 ЭРҮҮЛ МЭНД	7-8
 СОЁЛ УРЛАГ	9
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	9
 ГЭМТ ХЭРЭГ	10-11
 ТӨСӨВ	11
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	12
 АЖ ҮЙЛДВЭР	13
 ХАРИЛЦАА ХОЛБОО	14
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	15
 ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ	16



ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

ХҮСНЭГТ 1. ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 3 сард

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025*
Суурин хүн ам, жилийн эцэст тоо	38 929	39 579	40 238	40 674	-
Шинээр төрсөн хүүхэд тоо	204	168	202	179	128
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн тоо	173	3 925	75	76	46
Бүртгэсэн гэмт хэрэг тоо	51	107	106	105	58
Орон нутгийн төсвийн орлого сая төгрөг	9 125.3	3 456.0	4 476.4	6 388.0	7 308.1
Орон нутгийн төсвийн зарлага сая төгрөг	8 368.9	3 428.4	3 517.8	6 719.6	7 464.3

Эх үүсвэр: Налайх дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэс



ИРГЭНИЙ БҮРТГЭЛ


2025 оны эхний 3 сард шинээр төрсөн 128 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн авч, нас барсан 64 хүнийг бүртгэлээс хасаж, 30 хосын гэрлэлт, 8 хосын гэр бүл цуцлалтыг тус тус бүртгэсэн байна.

Шинээр мэндэлсэн хүүхдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 (13.5%), нас баралт 12 (15.8%) тус тус буурсан байна. Нийт мэндэлсэн хүүхдийн 52.3 хувь нь хүү, 47.7 хувь нь охин байна. Нийт нас баралтын 68.7 хувь нь эрэгтэй, 31.3 хувь нь эмэгтэй иргэн эзлэж байна.

ХҮСНЭГТ 2. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТЫН БҮРТГЭЛ, жил бүрийн эхний 3 сард

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025*
Төрсөн хүүхэд, бүгд	208	165	176	148	128
Үүнээс: Эрэгтэй	111	66	93	89	67
Эмэгтэй	97	99	83	59	61
Нас баралт, бүгд	48	71	56	76	64
Үүнээс: Эрэгтэй	31	45	31	47	44
Эмэгтэй	17	26	25	29	20

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ



ХҮСНЭГТ 3. ГЭРЛЭЛТЭЭ БҮРТГҮҮЛСЭН ХОС, насны бүлгээр, жил бүрийн эхний 3 сард

Үзүүлэлт	2023		2024		2025*	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
Нийт	49	49	38	38	30	30
18-19	-	1	-	1	-	-
20-24	9	7	8	11	6	9
25-29	13	20	12	10	9	7
30-34	10	9	6	6	3	3
35-39	8	6	2	2	9	6
40-44	7	3	3	2	1	4
45-49	-	2	4	2	1	-
50+	2	1	3	4	1	1

2025 оны эхний 3 сард гэрлэлтээ баталгаажуулсан 30 хос байгааг өмнөх оны мөн үетэй 8 (21.0%) буурсан байна. Хосуудыг насны бүлгээр нь авч үзвэл 25.0% нь 20-24 насны, 26.6% нь 25-29 насны, 10.0% нь 30-34 насны, 25.0% нь 35-39 насны, 8.3% нь 40-44 насны, 1.7% нь 45-49 насны, 3.4% нь 50 дээш насныхан байна.

ХҮСНЭГТ 4. ГЭР БҮЛ ЦУЦЛАЛТ, жил бүрийн эхний 3 сар

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025*	
Гэр бүл цуцлалт, бүгд	10	14	18	21	8	
1 хүртэл	-	1	1	5	-	
1-3	4	2	-	1	2	
Гэр бүл байсан	4-6	1	3	2	5	1
хугацаагаар (жилээр)	7-9	1	1	6	3	1
10-14	2	4	3	6	2	
15-19	-	-	2	1	-	
20 ба түүнээс дээш	2	3	4	-	2	

2025 оны эхний 3 сард нийт 8 хос гэр бүлээ цуцлуулсан байна. Гэр бүл байсан хугацаагаар нь ангилбал, 25.0% нь 1-3 жил, 12.5% нь 4-6 жил, 12.5% нь 7-9 жил, 25.0% нь 10-14 жил, 25.0% нь 20 түүнээс дээш жил ханилсан хосууд байна. Дүүргийн хэмжээнд гэр бүл цуцлалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 (61.9%) буурсан байна.

Дүүрэгт 2025 оны эхний 3 сард 1 хүүхэд үрчлэгдсэн байна.

ХҮСНЭГТ 5. ҮРЧЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ, насны бүлгээр, жил бүрийн эхний 3 сард

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025*
Үрчлэгдсэн хүүхэд, бүгд	3	2	5	5	1
0-3 хүртэл	3	-	3	3	1
3-6	-	-	-	-	-
7-9	-	1	1	1	-
10 ба түүнээс дээш	-	1	1	1	-

Эх үүсвэр: Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс



НИЙГМИЙН ДААТГАЛ

2025 оны эхний 3 сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 5745.4 сая төгрөгт хүрч, нийгмийн даатгалын санд төвлөрчээ.


Нийгмийн даатгалын сангаас 2025 оны эхний 3 сард 15346 даатгуулагч иргэнд 17374.7 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.

ХҮСНЭГТ 6. НИЙГМИЙНДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, жил бүрийн эхний 3 сард

Үзүүлэлт	2024		2025*	
	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая.төг)	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая.төг)
Нийт орлого	-	3 621.1	-	5 745.4
Тэтгэврийн даатгалын сан		3 049.1		4 764.5
Тэтгэмжийн даатгалын сан		313.5		505.4
ҮОМШӨ-ний даатгалын сан		201.8		306.4
Ажилгүйдлийн даатгалын сан		56.7		169.1
Нийт зардал	16 281	15 496.0	15 346	17 374.7
Тэтгэврийн даатгалын сан	14 415	13 746.8	13 683	14 828.4
Өндөр насны тэтгэвэр	11 291	10 435.1	9 538	10 790.5
Тахир дутуугийн тэтгэвэр	1 510	492.9	1 752	1 412.4
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	591	190.5	861	541.2
Цэргийн тэтгэвэр	1 023	2 628.2	1 532	2 084.3
ҮОМШӨ-ний даатгалын сан	1 179	974.5	1 111	1 067.4
Тахир дутуугийн тэтгэвэр	1 079	938.7	1 072	1 036.1
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	67	33.1	32	21.6
Сувилалын зардал	30	2.7	5	1.4
ҮОМШӨ ХЧТА ¹	-	-	2	8.3
Тэтгэмжийн даатгалын сан	229	452.8	299	842.7
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	64	22.3	131	73.2
Жирэмсний амралт	107	313.0	118	669.5
Оршуулга	58	117.5	50	100.0
Ажилгүйдлийн даатгалын сан	458	321.9	253	636.2
Ажилгүйдлийн тэтгэмж	458	321.9	253	636.2

¹ Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн чадвараа түр алдсан

ЗУРАГ 2. ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА



Тэтгэвэрийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо оны эхний 3 сард 13683 иргэнд олгосон тэтгэвэрийн хэмжээ 14828.4 сая төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэвэрийн 62.1 хувийг өндөр настны, 8.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 3.1 хувийг тэжээгчээ алдсан, 12.0 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.

Эх үүсвэр: Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газар



ЭРҮҮЛ МЭНД

2025 оны эхний 3 сард амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үетэй ижил, нас баралт 12 хүнээр (17.6%) буурсан байна.

ХҮСНЭГТ 7. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 3 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025*
Амаржсан эхийн тоо, бүгд	167	202	178	178
Амьд төрсөн хүүхэд	168	205	179	177
Амьгүй төрсөн	1	-	2	1
Эхийн эндэгдэл	-	-	-	-
Нас баралт	62	60	68	56
Үүнээс: нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	4	3	1	3
Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт	5	2	14	17
Гэрийн нөхцөлд гарсан нас баралт	38	45	38	22
Улаанбаатар хотод бүртгэгдсэн нас баралт ²	19	13	16	17

2025 оны эхний 3 сард нийт нас баралтын 39.2 хувийг гэрийн орчин нөхцөлд гарсан нас баралт эзэлж байгаа бол 30.4 хувийг Улаанбаатар хотод хэвтэн эмчлүүлж байгаад нас барсан, 30.4 хувийг дүүргийн эмнэлэгт гарсан нас баралт эзэлж байна.

² Дүүргийн харьяат иргэдээс Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж байгаад гарсан нас баралт

ХҮСНЭГТ 8. ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний 3 сард


Үзүүлэлт	2022	2023	2024	2025*
Нийт халдварт өвчин	3 925	75	76	46
Хурц халдварт өвчин:	3 872	11	31	10
Хепатит В вирус	-	-	-	-
Хепатит С вирус	-	-	-	1
Салхин цэцэг	4	8	27	5
Менингококкт халдвар	-	1	-	1
Бруцеллез	-	-	1	1
Дизентери	-	-	-	1
Гар, хөл,амны өвчин	-	1	-	1
Хумхаа	1	-	2	-
Улаан эсэргэнэ	1	-	-	-
Ковид	1	-	-	-
Сүрьеэ	3	12	7	6
Арьс өнгөний өвчин	50	52	38	30
Тэмбүү	19	26	15	17
Заг хүйтэн	19	14	7	13
Бэлгийн замын мөөгөнцөр	3	7	12	-
Трихомониаз	9	5	4	-

Дүүргийн хэмжээнд нийт халдварт өвчинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30 хүнээр (39.5%), хурц халдварт өвчин 21 (67.7%), арьс өнгөний өвчлөл 8 (21.0%), сүрьеэ 1 (14.3%) тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 9. ЭМНЭЛГИЙН ҮЗЛЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 3 сард

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025*
Урьдчилан сэргийлэх тарилга	1 672	1 493	1 559	1 374	1 378
Ор хоног	8 087	15 582	16 058	16 122	14 801
Амбулаторын үзлэг	51 427	58 953	56 693	54 270	58 377
Орны тоо	227	325	225	227	245
Эмчийн тоо	84	84	93	94	96
Сувилагчийн тоо	100	100	108	111	118

ЗУРАГ 3. ЭМНЭЛГИЙН ҮЗЛЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Эх үүсвэр: Налайх дүүргийн эрүүл мэндийн төв



СОЁЛ УРЛАГ

Дүүргийн соёл, урлагийн байгууллага 2025 оны эхний 3 сард нийтдээ 7 төрлийн 29 ажил, үйлчилгээг явуулж, 4735 хүнд үйлчилсэний 1908 том хүн, 2827 нь хүүхэд байна. Үйлчилгээний нийт орлого 7.7 сая төгрөг байна.

ХҮСНЭГТ 10. СОЁЛ, УРЛАГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, эхний 3 сард

Ажил үйлчилгээ	Нийт	Үүнээс						Номын сан (уншигчид)	ОНСТ үзэгчид
		Урлагийн тоглолт	Олон нийтийн ажил	Хурал цуглаан	Кино үзвэр	Уралдаан тэмцээн	Дугуйлан сургалт		
Бүгд	29	4	4	4	4	1	10	1	1
Үйлчлүүлэгчийн тоо									
Нийт	4735	855	1104	285	2021	172	189	33	76
Том хүн	1908	785	550	285	256	-	-	9	23
Хүүхэд	2827	70	554	-	1765	172	189	24	53

Эх үүсвэр : Налайх дүүргийн Соёлын ордон



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

2025 оны эхний 3 сард хот тохижилтын ажил үйлчилгээний нийт орлого 178.5 сая төгрөг болж, орлогын 43.7 хувийг орон сууц, 43.1 хувийг гэр хороолол, 13.2 хувийг аж ахуйн нэгжээс хуримтлуулсан орлого эзэлж, нийтдээ 18.2 мянган тонн хогийг зөөж, тээвэрлэсэн байна.

ХҮСНЭГТ 11. ХОТ ТОХИЖИЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 3 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025*	Үүнээс:		
					Орон сууцны	Гэр хороолол	ААНБ
Нийт орлого сая / төг	6.9	76.7	185.2	178.5	78.0	77.0	23.5
Хог тээвэрлэлт мян / тн	12.5	12.3	40.4	18.2	6.1	8.2	3.9

Эх үүсвэр: Налайх дүүргийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар

2025 оны эхний 3 сард дүүргийн хэмжээнд 145.7 мянган м³ ус борлуулснаас, 91.1 мянган м³ (62.5%) усыг хүн амд, 54.6 мян.м³ (37.5%) усыг аж ахуйн нэгж байгууллагад түгээсэн байна.

ХҮСНЭГТ 12. ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ, жил бүрийн эхний 3 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025*
Шахсан ус мянган м ³	200.6	176.9	184.6	209.6
Борлуулсан ус мянган м ³	158.3	139.2	118.9	145.7
Үүнээс: Хүн амд мянган м ³	113.4	79.8	78.1	91.1
Аж ахуйн нэгж байгууллагад мянган м ³	44.9	59.4	40.8	54.6
Татан зайлуулсан бохир мянган м ³	127.2	102.9	101.2	117.2
Ус борлуулалтын орлого сая төгрөг	287.7	255.2	204.0	259.5
Сувагжуулалтын орлого сая төгрөг	135.1	84.2	126.1	163.2
Халаалтын орлого сая төгрөг	122.4	161.1	118.8	118.5

Эх үүсвэр: Налайх дүүргийн Чандмань Налайх ОНӨААТҮГазар



ГЭМТ ХЭРЭГ

Дүүрэгт 2025 оны эхний 3 сард 58 гэмт хэрэг бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47 (44.8%) буурсан байна.


ЗУРАГ 4. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧИД, насны байдлаар



ХҮСНЭГТ 13. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 3 сард

Үзүүлэлт		2021	2022	2023	2024	2025*
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд		51	107	106	105	58
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг		4	7	4	2	-
Үүнээс	Санаатай	4	1	-	-	-
	Учрал	-	6	4	2	-
Хүчин		3	3	2	2	3
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		-	1	2	1	-
Бусдын бие махбодид гэмтэл учруулсан		27	48	37	47	25
Өмчлөх эрхийн гэмт хэрэг		17	37	47	47	17
Үүнээс	Хулгай	12	15	9	9	4
	Залилах	3	17	29	29	7
	Хөрөнгө завших	-	-	2	1	1
	Алдаатай гүйлгээ, гээгдсэн эд хөрөнгө завших	-	-	4	3	1
	Эд хөрөнгө устгах гэмтээх	-	-	1	4	2
	Авто тээвэр хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явах	2	2	1	1	2
	Дээрэм	-	3	1	-	-
Бусад		-	11	14	6	13
Гэмт хэрэгт холбогдогчид, бүгд		41	71	85	58	36
Ажилгүй		-	50	63	14	20
Албан хаагч		-	4	3	5	3
Оюутан, сурагч		-	6	3	5	1
Төрийн бус байгууллагын ажилтан		-	1	5	4	1
ХХЭ болон хувийн хэвшилд ажиллагч		10	10	10	27	11
Эрүүлжүүлэгдсэн хүн		650	511	303	146	103
Үүнээс: Эмэгтэй		-	64	18	11	-

ЗУРАГ 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороодоор



Гэмт хэргийн улмаас 78 хүн гэмтэж бэртсэн үүнээс 2 хүн нас барсан бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийтдээ 713.5 сая төгрөгийн хохирол учруулсны 308.3 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна. 2025 оны эхний 3 сард 11377 зөрчил бүртгэж, 11228 иргэн, 9 хуулийн этгээдийг 268.3 сая төгрөгөөр торгож, 103 хүнийг эрүүлжүүлж, 23 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

Эх үүсвэр: Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс



ТӨСӨВ

2025 оны эхний 3 сард дүүргийн төсөвт 6080.2 сая төгрөгийн татварын орлого төвлөрсөн байна.

ЗУРАГ 6. ОРОН НУТГИЙН ТАТВАРЫН ОРЛОГО, төрлөөр



Эх үүсвэр: Налайх дүүргийн Татварын хэлтэс



ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Түүхий эдийн үнэ өмнөх оны мөн үеэс ямааны ноолууртай арьс 15000 төгрөг, адууны дэл 1000 төгрөгөөр өсөж, тэмээний шир 20000 төгрөг, адууны шир 2000 төгрөгөөр тус тус буурч, адууны сүүл, үхрийн шир, ноолуур өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

ХҮСНЭГТ 14. ЗАРИМ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ, жил бүрийн эхний 3 сард

Түүхий эдийн нэр	2021	2022	2023	2024	2025*
	төгрөг				
Тэмээний шир ширхэг	65 000	10 000	30 000	80 000	60 000
Адууны шир ширхэг	7 000	12 000	10 000	12 000	10 000
Адууны дэл кг	10 000	5 000	5 000	1 500	2 500
Адууны сүүл кг	15 000	7 000	10 000	10 000	10 000
Үхрийн шир (дундаж үнэ) 1.8-2.3 метр хэмжээтэй ширхэг	11 000	5 000	11 000	10 000	10 000
Хонины арьс ширхэг	1 500	-	-	-	-
Ямааны ноолууртай арьс ширхэг	35 000	35 000	35 000	50 000	65 000
Ноолуур кг	120 000	150 000	14 0000	150 000	150 000


Эх үүсвэр: Дүүргийн хөдөө аж ахуйн сарын мэдээ

ХҮСНЭГТ 15. ШАТАХУУН ҮНЭ, литр, төгрөг, жил бүрийн 3 сард

ШТС	2024. 03. 27					2025. 03. 25				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	-	2 390	3 590	-	-	-	2 390	3 140	-
Петровис	3 910	2 370	2 390	3 590	-	3 710	2 370	2 390	3 140	-
Магнай трейд	3 910	-	2 390	3 590	-	3 710	-	2 390	3 140	-
Сод монгол	3 910	2 315	2 390	3 590	-	3 710	2 315	2 390	3 140	-
Шунхлай	3 910	2 350	2 390	3 590	-	3 710	2 350	2 390	3 140	-
Юнигаз	-	-	-	-	1 790	-	-	-	-	1 790
Дундаж үнэ	3 910	2 345	2 390	3 590	1 790	3 710	2 345	2 390	3 140	1 790

Эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газрын 7 хоногийн үнийн судалгааны дүн

ЗУРАГ 7. ШАТАХУУНЫ ДУНДАЖ ҮНЭ, литр төгрөг, 3 сард





АЖ ҮЙЛДВЭР

2025 оны эхний 3 сард үйлдвэрлэгдсэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан хангамж 10.4 хувиар буурч, цахилгаан эрчим хүч 11.4 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, жил бүрийн эхний 3 сард

Үзүүлэлт	Нийт үйлдвэрлэлт					
	Биет хэмжээгээр			Үнийн дүнгээр, сая/төг		
	2023	2024	2025*	2023	2024	2025*
Эрчим хүчний үйлдвэр						
Цахилгаан сая.квт.цаг	51.1	66.6	74.2	10 946.1	13 408.1	19 204.8
Дулаан мянган гкал	38.7	42.3	37.9	2 216.7	2 165.5	3 674.1
Боловсруулах үйлдвэр						
Элс мянган м ³	-	4.9	0.867	-	69.1	14.2
Хайрга мянган м ³	-	0.35	3.155	-	5.6	65.9
Дайрга мянган м ³	-	0.2	-	-	3.0	-
Аюултай хог хаягдал булах тонн	160.6	223.7	283.3	210.2	299.7	379.7
Аюулгүй хог хаягдал зайлуулах тонн	10 397	40 410.0	18 248.8	232.1	232.1	616.3
Оёдол /сурагчийн дүрэмт хувцас/ мянган ширхэг	-	-	869	-	-	55.2
Берзинтэн цүнх ширхэг	144.0	-	-	8.6	-	-
Резинэн эдлэл сая.төг	-	-	1 307.3	-	-	1 307.3
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл						
Талх тонн	1.1	1.2	2.6	4.0	2.6	11.4
Нарийн боов, жигнэмэг тонн	1.3	1.6	2.9	4.7	6.0	11.0
Утсан, чанасан болон хагас боловсруулсан мах тонн	338.2	-	-	4 900.0	-	-
Үхрийн мах тонн	20.29	27.4	5.49	161.5	241.4	131.8
Хонины мах тонн	47.0	106.0	8.49	298.9	787.9	99.5
Ямааны мах тонн	-	-	2.08	-	-	16.2
Цэвэр ус мян. литр	2 300.0	3 290.0	2 334	810.0	1 155.3	730.5

*Урьдчилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Дүүргийн аж үйлдвэрийн сарын мэдээ



МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

Телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 69 (8.1%) буурсан байна. Нийт суурин телефон цэгийн 431 (54.8%) нь айл өрхийн эзэмшилд байгаа бол 258 (32.8%) нь төсвийн байгууллагад, 98 (12.4%) нь бизнесийн байгууллагуудад ашиглагдаж байна.

ХҮСНЭГТ 17. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 3 сард

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025*
Нийт орлого сая төгрөг	65.3	93.4	110.4	129.6	132.0
Үүнээс: хүн амд үзүүлсэн үйлчилгээний сая төгрөг	32.0	45.8	54.1	63.5	64.7
Телефон цэг тоо	792	724	930	856	787
Үүнээс: айл өрх тоо	505	426	517	462	431
Интернет үйлчилгээний цэг тоо	2	2	2	2	2
Интернет үйлчилгээний суудал тоо	17	17	2	2	2
Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчид тоо	210	550	505	400	380
Интернетийн байнгын хэрэглэгчид тоо	110	480	715	438	665

Эх үүсвэр: Налайх дүүргийн холбооны газар



АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2025 оны эхний 3 сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтийг 70 объектод хийснээс, 294 зөрчил илрүүлэн, 238 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 43, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 18, танилцуулга 3, гал түймэр унтраасан нотломж 34, гал түймэр гаргасан тухай акт 9 хүргүүлсэн байна. Мөн объектын гал түймрийн 34 дуудлагаар ажиллаж 1205.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

ХҮСНЭГТ 18.ГАЛ ТҮЙМРИЙН ДУУДЛАГА, жил бүрийн эхний 3 сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021	2022	2023	2024	2025*
Бүгд		12	14	17	25	34
Өмчийн хэлбэрээр						
Төрийн өмч	тоо	-	1	1	-	-
Хувийн өмч	тоо	12	10	14	15	26
Аж ахуйн нэгж	тоо	-	3	2	10	8
Гал түймэрт өртөж шатсан						
Нас барсан	хүүхэд	-	-	-	-	-
	том хүн	-	-	-	-	-
Түлэгдэж бэртсэн	хүүхэд	-	-	-	-	-
	том хүн	-	-	-	-	-
Өвөл зуны сууц	тоо	7	4	6	16	19
Гэр	тоо	2	4	7	5	8
Хог, хогийн суваг	тоо	2	3	4	1	1
Машин техник	тоо	1	2	-	2	5
Барилга байгууламж	тоо	-	1	-	-	1
Малын хашаа	тоо	-	-	-	1	-
Шалтгаан						
Цахилгааны	тоо	3	7	10	12	30
Ил задгай асгасан үнс, нурмаас	тоо	3	2	1	-	-
Лаа, тамхи, шүдэнз	тоо	2	1	1	1	-
Пийшин зуухны цонолт	тоо	1	2	5	9	1
Машин техник гэмтэл, буруу ашигласан	тоо	1	1	-	2	1
Архидалтаас	тоо	2	1	-	1	-
Шалтгаан тогтоогдоогүй	тоо	3	7	10	12	1
Санаатай үйлдлээр	тоо	-	-	1	-	1
Аварсан эд хөрөнгө						
Өвөл зуны сууц	тоо	5	3	3	-	6
Барилга байгууламж	тоо	-	3	3	-	17
Машин техник	тоо	1	3	3	4	-
Эд хөрөнгө	сая төг	221.0	1207.0	305.0	524.0	1 205.0

Эх үүсвэр: Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн сарын мэдээ

2025 оны эхний эхний 3 сард дүүргийн Засаг даргын 3 удаагийн захирамжаар нийт 81 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой захирамж гарсанаас 62 иргэн, 19 аж ахуйн нэгж байгууллагын асуудлыг шийдвэрлэсэн. Албаны даргын 12 удаагийн тушаалаар нийт 230 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын захирамж гарсанаас 223 иргэн, 7 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна.

ХҮСНЭГТ 19. ГАЗАРТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭЛТ, жил бүрийн эхний 3 сард

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг хүчингүй болгох	Газар эзэмших эрх олгох, баталгаажуулах	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар өмчлөх	Хамтран өмчлөгч	Газрын байршил, талбайг өөрчлөх	Газар эзэмших эрх сэргээх хугацаа сунгах	Газар эзэмших эрхээ цуцлуулах хүсэлт гаргасан
Иргэн, ААНБ-ын тоо	18	-	-	217	-	-	59	17	-

Эх үүсвэр: Налайх дүүргийн Газар зохион байгуулалтын алба



ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727, 1800-1200 тусгай дугаарын утас, Засгийн газрын 11-11 утас, www.ub1200.mn цахим хуудас, дижитал сити, Check my service аппликейшн зэргээр иргэдийн гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2025 оны эхний 3 сард дүүргийн Засаг Даргын Тамгын газарт нийт 434 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсан байна. Эдгээрээс 416 санал, хүсэлт, өргөдөлд хариу өгч, 18-д хариу өгөх хугацаа болоогүй болон судлагдаж байна. Санал хүсэлтийн шийдвэрлэлт 95.0 хувьтай байна. Ирсэн өргөдөл, гомдол саналын 361 (83.2%) нь бичгээр, 73 (16.8%) нь утсаар болон цахим системээр ирсэн байна.

Эх үүсвэр: Налайх дүүргийн ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээ

Танилцуулгыг татаж авах линк : <http://www.ubstat.mn/Report>
 Налайх дүүргийн Статистикийн хэлтэс facebook page хуудас
 Утас: 7023-3672